**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/70/НА-СТА-ТШЗ**

| | | |
|---|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn | 2024 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :Баян ташаагийн эх Аудит ХХК<br>Захирал: Т.Хоролсүрэн<br>Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3. Санхүүгийн тайлангийн тодруулга.................................................................................................

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл .........................................................................................................................

4.2 Материаллаг байдал ...............................................................................................................

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..........................................................................................

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..............................................................

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................................................................................

5. Аудитын илрүүлэлт .....................................................................................................................

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/75

танай ____________-ны № ____________ -т

БАЯНЦАГААН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.НАНДИНЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Чиглэл батлах тухай” 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу багш, байгууллагын гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээгээр 54,666.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Мөн 38,229.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 6,700.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил нэмэгджээ.

5020282

**Аудитын гол асуудал**

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 518,660.9 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд төсвийн захирагч 9 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 53 арга хэмжээг бүрэн, 1 арга хэмжээг 70 хувь буюу нийт дүнгээр 95.2 хувиар биелүүлж биелэлтийг хүргүүлсэн дээд байгууллагаас 84 хувиар дүгнэгдсэн.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **138,895,985.66** | **364,941,779.80** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **19,575,795.26** | **227,039,941.90** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **19,575,795.26** | **227,039,941.90** |
| **3121** | **Төгрөг** | **19,575,795.26** | **227,039,941.90** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 19,575,795.26 | 227,039,941.90 |
| **33** | **АВЛАГА** | **1,173,118.00** | **1,110,600.00** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 1,110,600.00 | 1,110,600.00 |
| 335 | Бусад авлага | 62,518.00 | |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 62,518.00 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **118,147,072.40** | **136,791,237.90** |
| **351** | **Түүхий эд материал** | **29,615,827.00** | **36,247,942.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 22,874,027.00 | 30,351,442.00 |
| 35130 | Эм боох материал | 6,741,800.00 | 5,896,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **88,531,245.40** | **100,543,295.90** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 730,000.00 | 730,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 56,459,840.00 | 57,659,840.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,367,000.00 | 218,400.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 28,974,405.40 | 41,935,055.90 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,705,809,343.92** | **1,463,002,946.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,705,809,343.92** | **1,463,002,946.10** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,672,778,219.02** | **1,430,074,946.10** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,642,407,402.00 | 1,354,780,119.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -221,519,859.96 | -235,689,373.90 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 374,073,191.50 | 467,134,971.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -220,402,884.22 | -269,558,085.74 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 123,285,049.36 | 150,836,049.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -77,748,229.06 | -87,966,550.20 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 48,253,449.00 | 48,253,449.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -12,534,165.74 | -14,679,899.06 |
| 39217 | Ном | 16,964,266.14 | 16,964,266.14 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **33,031,124.90** | **32,928,000.00** |
| 39301 | Програм хангамж | 955,000.00 | 955,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -851,875.10 | -955,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,928,000.00 | 32,928,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,844,705,329.58** | **1,827,944,725.90** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,844,705,329.58** | **1,827,935,725.90** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,844,705,329.58** | **1,827,935,725.90** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 413,542,036.70 | 413,542,036.70 |
| 51101 | Өмч: - төрийн | 413,542,036.70 | 413,542,036.70 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **95,228,867.58** | **274,335,026.78** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 95,228,867.58 | 291,104,630.46 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | -16,769,603.68 |
| **51300** | **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | **1,335,934,425.30** | **1,140,058,662.42** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,844,705,329.58** | **1,827,944,725.90** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,498,969,200.00** | **1,951,186,902.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **58,980,000.00** | **76,984,265.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,461,800.00** | **76,984,265.50** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,461,800.00 | 2,421,300.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,461,800.00 | 2,421,300.00 |
| **122** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **57,518,200.00** | |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 57,518,200.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,439,989,200.00** | **1,874,202,637.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,252,321,900.00** | **1,729,541,400.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,252,321,900.00 | 1,729,541,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **187,667,300.00** | **144,163,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 187,667,300.00 | 144,163,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,434,792,840.68** | **1,727,345,221.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,434,792,840.68** | **1,727,345,221.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,406,790,376.20** | **1,603,571,520.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **920,763,784.04** | **1,069,883,145.81** |
| 210101 | Үндсэн цалин | 614,662,809.53 | 711,886,658.04 |
| 210102 | Нэмэгдэл | 234,473,230.51 | 299,150,288.00 |
| 210104 | Урамшуулал | 35,665,964.10 | 58,846,199.77 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 35,961,779.90 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **114,851,833.92** | **137,514,980.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 78,406,012.08 | 94,215,368.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,111,529.39 | 10,932,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,289,123.22 | 8,727,612.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,822,304.34 | 2,148,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,222,864.89 | 21,490,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **122,820,273.00** | **129,310,536.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,680,014.00 | 10,742,916.00 |
| 210302 | Түлш, халаалт | 114,640,259.00 | 116,767,620.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 1,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **34,758,431.30** | **4,077,130.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,409,020.00 | 2,817,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,588,161.30 | 680,130.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,161,200.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,941,800.00 | 580,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 7,658,250.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | **136,611,250.00** | **86,642,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | 136,611,250.00 | 86,642,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,816,000.00** | **2,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 7,816,000.00 | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,208,200.00** | **7,006,300.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 351,200.00 | 2,281,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,857,000.00 | 4,725,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **65,960,603.94** | **167,137,428.69** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,176,600.00 | 38,463,235.55 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 250,000.00 | 5,866,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 50,534,003.94 | 122,807,893.14 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,002,464.48** | **123,773,701.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **11,564,000.00** | **108,772,637.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,564,000.00 | 41,673,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **16,438,464.48** | **15,001,064.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,438,464.48 | 15,001,064.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **64,176,359.32** | **223,841,681.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН** | **64,176,359.32** | **-16,769,603.68** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,441,451,000.00** | **1,876,623,937.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,461,800.00** | **2,421,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,461,800.00** | **2,421,300.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,461,800.00** | **2,421,300.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,461,800.00 | 2,421,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,439,989,200.00** | **1,874,202,637.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,252,321,900.00** | **1,729,541,400.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,252,321,900.00 | 1,729,541,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 187,667,300.00 | 144,163,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 187,667,300.00 | 144,163,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,385,214,204.74** | **1,618,553,910.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,385,214,204.74** | **1,618,553,910.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,289,620,740.26** | **1,496,619,109.36** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 920,763,784.04 | 1,069,883,145.81 |
| 210101 | Үндсэн цалин | 614,662,809.53 | 711,886,658.04 |
| 210102 | Нэмэгдэл | 234,473,230.51 | 299,150,288.00 |
| 210104 | Урамшуулал | 35,665,964.10 | 58,846,199.77 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 35,961,779.90 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 114,914,351.92 | 137,452,462.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 78,468,530.08 | 94,152,850.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,111,529.39 | 10,932,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,289,123.22 | 8,727,612.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,822,304.34 | 2,148,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,222,864.89 | 21,490,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 122,457,833.00 | 127,161,936.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,680,014.00 | 10,742,916.00 |
| 210302 | Түлш, халаалт | 114,277,819.00 | 114,619,020.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 1,800,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 69,020,250.00 | 88,480,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 69,020,250.00 | 88,480,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,314,000.00 | 2,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,314,000.00 | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,540,000.00 | 9,026,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,461,800.00 | 2,281,300.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,078,200.00 | 6,745,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 43,610,521.30 | 62,614,365.55 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,992,576.30 | 48,948,065.55 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,617,945.00 | 13,666,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **95,593,464.48** | **121,934,801.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 79,155,000.00 | 106,933,737.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 67,591,000.00 | 64,762,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,564,000.00 | 41,673,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 16,438,464.48 | 15,001,064.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,438,464.48 | 15,001,064.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **56,236,795.26** | **258,070,026.64** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **36,661,000.00** | **50,605,880.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **36,661,000.00** | **50,605,880.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 36,661,000.00 | 50,605,880.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 36,661,000.00 | 50,605,880.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-36,661,000.00** | **-50,605,880.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **19,575,795.26** | **207,464,146.64** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **19,575,795.26** | **227,039,941.90** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,336,761,282.30** | **31,052,508.26** | **1,781,355,827.26** |
| 2 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,336,761,282.30** | **31,052,508.26** | **1,781,355,827.26** |
| **3** | **Тайлант үеийн үр дүн** | | | 64,176,359.32 | 64,176,359.32 |
| **4** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,335,934,425.30** | **95,228,867.58** | **1,844,705,329.58** |
| **5** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -195,875,762.88 | | -195,875,762.88 |
| 6 | Тайлант үеийн үр дүн | | | -16,769,603.68 | -16,769,603.68 |
| 7 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **413,542,036.70** | **1,140,058,662.42** | **274,335,026.78** | **1,827,935,725.90** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| **код** | **Үзүүлэлт** | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,919,464,300.00** | **1,651,616,614.36** | **267,847,685.64** | **86.0** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **1,919,464,300.00** | **1,651,616,614.36** | **267,847,685.64** | **86.0** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **1,794,405,900.00** | **1,545,181,114.36** | **249,224,785.64** | **86.1** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,250,988,600.00** | **1,067,839,270.81** | **183,149,329.19** | **85.4** |
| 210101 | Үндсэн цалин | 842,770,500.00 | 709,842,783.04 | 132,927,716.96 | 84.2 |
| 210102 | Нэмэгдэл | 348,305,300.00 | 299,150,288.00 | 49,155,012.00 | 85.9 |
| 210104 | Урамшуулал | 59,912,800.00 | 58,846,199.77 | 1,066,600.23 | 98.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **156,372,900.00** | **137,452,462.00** | **18,920,438.00** | **87.9** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 106,333,600.00 | 94,152,850.00 | 12,180,750.00 | 88.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,509,800.00 | 10,932,600.00 | 1,577,200.00 | 87.4 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 10,007,900.00 | 8,727,612.00 | 1,280,288.00 | 87.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,501,900.00 | 2,148,700.00 | 353,200.00 | 85.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,019,700.00 | 21,490,700.00 | 3,529,000.00 | 85.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **163,943,000.00** | **127,161,936.00** | **36,781,064.00** | **77.6** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 7,339,600.00 | 10,742,916.00 | -3,403,316.00 | 146.4 |
| 210302 | Түлш, халаалт | 154,803,400.00 | 114,619,020.00 | 40,184,380.00 | 74.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,800,000.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **90,750,300.00** | **88,480,900.00** | **2,269,400.00** | **97.5** |
| 210502 | Хоол, хүнс | 90,750,300.00 | 88,480,900.00 | 2,269,400.00 | 97.5 |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **2,000,000.00** | **2,000,000.00** | **-** | **100.0** |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **13,392,300.00** | **9,026,300.00** | **4,366,000.00** | **67.4** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,281,300.00 | 2,281,300.00 | 2,000,000.00 | 53.3 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 9,111,000.00 | 6,745,000.00 | 2,366,000.00 | 74.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **116,958,800.00** | **113,220,245.55** | **3,738,554.45** | **96.8** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 103,292,300.00 | 99,553,945.55 | 3,738,354.45 | 96.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,666,500.00 | 13,666,300.00 | 200.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **125,058,400.00** | **106,435,500.00** | **18,622,900.00** | **85.1** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 125,058,400.00 | 106,435,500.00 | 18,622,900.00 | 85.1 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 83,384,400.00 | 64,762,500.00 | 18,621,900.00 | 77.7 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 41,674,000.00 | 41,673,000.00 | 1,000.00 | 100.0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,899,905,700.00** | **1,861,124,636.00** | **38,781,064.00** | **98.0** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,729,541,400.00** | **1,729,541,400.00** | **-** | **100.0** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,729,541,400.00 | 1,729,541,400.00 | - | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **165,943,000.00** | **129,161,936.00** | **36,781,064.00** | **77.8** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 165,943,000.00 | 129,161,936.00 | 36,781,064.00 | 77.8 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **4,421,300.00** | **2,421,300.00** | **2,000,000.00** | **54.8** |
| 120004 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,281,300.00 | 2,421,300.00 | 1,860,000.00 | 56.6 |
| 120004 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 140,000.00 | - | 140,000.00 | - |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **19,575,795.26** | **-19,575,795.26** | **-** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **227,039,941.90** | **-227,039,941.90** | **-** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **67** | **67** | **-** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 44 | 44 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 22 | 22 | - | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### **3.1.1** Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд суралцагчдын мэдлэг чадвар, багшийн хөгжлийг дэмжих, хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллах чиг үүрэгтэй байгууллага юм. Тус байгууллага нь дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Суралцагсдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

### **3.2** Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль,



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс шинээр мөрдөгдөж эхэлсэн.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,760.6 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөг/*

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| | Б | 1 | 2 | 3=2-1 |
| 1 | Мөнгөн хөрөнгө | 19,575.8 | 227,039.9 | 207,464.1 |
| 2 | Авлага | 1,173.1 | 1,110.6 | -62.5 |
| 3 | Бараа материал | 118,147.1 | 136,791.2 | 18,644.2 |
| 4 | Үндсэн хөрөнгө | 2,238,866.3 | 2,071,851.8 | -167,014.5 |
| 5 | Хуримтлагдсан элэгдэл | -533,057.0 | -608,848.9 | -75,791.9 |
| **5** | **Нийт хөрөнгө** | 1,844,705.3 | 1,827,944.7 | -16,760.6 |
| 6 | Засгийн газрын хувь оролцоо | 1,844,705.3 | 1,827,944.7 | -16,760.6 |
| **7** | **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,844,705.3 | 1,827,944.7 | -16,760.6 |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 227,039.9 мянган төгрөг болж 207,464.1 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүжсэнтэй холбоотой байна.
- Өмнөх оны түрээсийн сурах бичгийн түрээсийн төлбөрийг барагдуулаагүйгээс авлага данс үлдэгдэлтэй байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 136,791.2 мянган төгрөг болж, 18,644.2 мянган төгрөгөөр өссөн нь шатах тослох материал 2,148.6 мянган төгрөг, эм боох материал 845.3 мянган төгрөгөөр буурч, тусгай зориулалтай материал 7,477.4 мянган төгрөг, аж ахуйн материал 1,200.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 12,960.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материалын үлдэгдэл өссөхөд нөлөөлжээ.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,463,002.9 мянган төгрөг болж 242,806.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 55,100.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө 65,511.9 мянган төгрөг. Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 05 дугаар сарын 12-ний 14/28 тоот тогтоолоор акталсан үндсэн хөрөнгө 287,627.3 мянган төгрөг, тайлант хугацааны элэгдэлын зардал 122,807.9 мянган



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төгрөг акталсан хөрөнгийн элэгдэл 47,015.9 мянган төгрөг гарсантай холбоотой байна.

- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,827,944.7 мянган төгрөг болж 16,760.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 452,217.7 мянган төгрөгөөр өссөн, нийт зардал өмнөх оноос 292,552.4 мянган төгрөгөөр өссөн байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн шууд захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,090,863.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 765,170.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 1,753,521.3 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 165,943.0 мянган төгрөгөөр баталжээ.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн хүрээнд 11 арга хэмжээнд 1,729,541.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 165,943.0 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажллагааны орлогоос 4,281.3 мянган төгрөг, урд оны үлдэгдлээс 39,177,2 мянган, нийт 1,919,464,3 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,729,541.4 мянган, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогоос 2,421.3 мянган, орон нутгийн төсвөөс 129,161.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орон нутгийн төсвөөс байр ашиглалтын зардалд 127,161.9 мянган, эд хогшил, урсгал засварын зардалд 2,000.0 мянган, нийт 1,651,616.6 мянган төгрөгийг зарцуулж 129,161.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, улсын төсвөөс цалин, нийгмийн даатгалын зардлуудад 1,205,291.7 мянган, нормативт зардалд 88,480.9 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 9,026,3 мянган, бусад урсгал шилжүүлэгийн зардалд 106,435.5 мянган, бараа үйлчилгээний



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

бусад зардал 113,220.2 мянган, нийт 1,651,616.6 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 15,001.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн улсын төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,651,616.6 мянган төгрөг буюу 86.0 хувьтай, орон нутгийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 129,161.9 мянган төгрөг буюу 77.8 хувь байгаа нь улсын төсвийн зардлыг хэмнэн дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

| Д/д | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 71601 | Ерөнхий боловсролын сургалт | 1,919,464.3 | 1,651,616.6 | 267,847.7 | 86.0 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,677,447.1 | 1,431,960.9 | 245,486.2 | 86.2 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 125,058.4 | 106,435.5 | 18,622.9 | 85.1 |
| 83112 | Бараа үйлчилгээний бусад зардал | 116,958.8 | 113,220.2 | 3,738.6 | 96.8 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөл, арга хэмжээнд 143,862.9 мянган төгрөгийг тусгаж баталснаас, гүйцэтгэлээр 89,628.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хүүхдэд ээлтэй орчин төсөл хөтөлбөрийн хүрээнд 6,600.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авалтын аргаар, үдийн цай хөтөлбөрийн 43,038.2 мянган төгрөгийг харьцуулалтын аргаар, дотуур байрны хүнсний материалын 46,590.3 мянган төгрөгийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар харин бусад хангамж бичиг хэргийн 53,773.5 мянган төгрөгийн бараа материалыг шууд худалдан адалтын аргаар худалдаж авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн хооронд Баян ташаагийн эх аудит ХХК-ийн аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Хоролсүрэн, аудитын Ахлах аудитор М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 1,753,352.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 17,535.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материалаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 12,274.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхгүй арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин, нийгмийн даатгалын зардлуудад 202,069.8 мянган, нормативт зардалд 2,269.4 мянган, бусад урсгал шилжүүлэгийн зардалд 4,366.0 мянган төгрөгийн зарлуудыг хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар,худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, батлагдсан төсөв, тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, Цалингийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ,тушаал шийдвэрийг бүрэн мэдээлж, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, дараа жилийн төсвийн төсөл 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба хуулийн хэрэгжилт 98.3 хувьтай байна.Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 2,307,727.20 мянган төгрөгийн 111 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тогтоосон 2,456.7 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт, 11,702.7 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 560.3 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн биелүүлсэн байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт*

*/мянган төгрөг/*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 5 | 2,456.7 | 5 | 2,456.7 | 100.0 |
| Албан шаардлага | 5 | 11,702.7 | 5 | 11,702.7 | 100 |
| Зөвлөмж | 1 | 560.3 | 1 | 560.3 | 100.0 |
| **Нийт дүн** | **11** | **14,719.7** | **11** | **14,719.7** | **100.0** |
| | | | | | |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц зүйл байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,110.6 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, зөрчлийг нөхөн төлүүлэхээр 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 1,110.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 17,535.2 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1.1 Төлбөрийн акт

1. Түрээсийн төлбөртэй ашиглуулах сурах бичгийн 2022 оны түрээсийн төлбөр 1.110.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь БСШУС-ын сайдын 2019 оны 05-р сарын 14-ний өдрийн А/302 тоот тушаалын 1 дүгээр хавсралт: 3.2 Төлбөрийг төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн суралцагч нэмэлт санхүүжилтийн дансанд, төрийн бус сургуулийн суралцагч тухайн байгууллагын дансанд тушаана; гэсэн заалттай нийцэхгүй аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Түрээсийн төлбөртэй ашиглуулах сурах бичгийн 2022 оны түрээсийн үлдэгдэл төлбөр 1.110.6 мянган төгрөгийн авлагыг захирал С.Нандинцэцэг-р төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.1.2 Албан шаардлага

Шилэн дансны цахим системд Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар,худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, батлагдсан төсөв, тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, Цалингийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ,тушаал шийдвэрийг бүрэн мэдээлж, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, дараа жилийн төсвийн төсөл 2 мэдээллийг хугацаа хоцроож



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

мэдээлсэн ба хуулийн хэрэгжилт 98.3 хувьтай байна.Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 2,307,727.20 мянган төгрөгийн 111 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хэрэгжүүлээлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | То о | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн |
| Түрээсийн төлбөртэй ашиглуулах сурах бичгийн 2022 оны түрээсийн төлбөр 1.110.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. | 1 | 1,110.6 | 1 | 1.110.6 | | | | |
| Дүн | 1 | 1,110,6 | 1 | 1,110.6 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ***Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил*** | | | | | | |
| Шилэн дансны цахим системд Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан , дараа жилийн төсвийн төслийн 2 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | | 1 | | | |
| Дүн | 1 | | 1 | | | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ